

**ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД
2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2022.12.01

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөгжлийн төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаар санал, зөвлөмж гарган, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөгжлийн төслийн жагсаалтын дагуу яамны холбогдох газруудаас гаргасан хэрэгжилтийн тайланг үндсэн мэдээлэл болгон авч үзэв.

Хоёр. Үндэслэл

Бодлогын хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан аргачлалын дагуу үнэлсэн.

Гурав. Танилцуулга

Хүснэгт 1

№	Төсөл арга хэмжээ	Төсөл арга хэмжээний тоо
1.	Төмөр замын төслүүд	9
2.	Авто замын төслүүд	17
3.	Нисэх онгоцны буудлын төслүүд	8
4.	Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүд	8
Нийт		42

Дөрөв. Үнэлгээ.

"Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 42 төсөлд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100 хувийн хэрэгжилттэй 6, 90 хувийн хэрэгжилттэй 1, 70 хувийн хэрэгжилттэй 2, 50 хувийн хэрэгжилттэй 3, 30 хувийн хэрэгжилттэй 10, хэрэгжилтийн хугацааг тооцох болоогүй 17, Зам, тээврийн хөгжлийн яамнаас үл хамаарах шалтгаантай 3 төсөл арга хэмжээ (хүснэгт 6-д үзүүлэв) байна. Нийт хэрэгжилт нь **58.2** хувьтай байна.

Хөгжлийн төслүүдийг салбар тус бүрээр ангилбал:

Хүснэгт 2

№	Бүлгүүд	Нийт төсөл арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь							Нийт хувь
			100	90	70	50	30	0	ХБ	
1	Төмөр замын төслүүд	9	2	-	-	-	4	-	3	53.3
2	Авто замын төслүүд	17	1	1	1	2	1	-	11	65.0

3	Нисэх онгоцны буудлын төслүүд	8	-	-	1	-	4	-	3	38.0
4	Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүд	8	3	-	-	1	1	-	3	76.0
Нийт		42	6	1	2	3	10	-	20	58.2

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувьтай 3 төсөл, арга хэмжээ:

Хүснэгт 3

№	Төсөл арга хэмжээ	Хэрэгжилт
Авто замын төслүүд		
1	Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ 202.4 км авто замын төсөл /ЕСБХБ/ (2020-2024 он)	<p>Дээрх төслийн зам барилгын ажлын 2022 оны нарийвчилсан график төлөвлөгөөг гаргаж, гүйцэтгэгчийн ажиллах хүч, мэргэжилтэнг гадаадаас авахад шаардагдах зөвшөөрлийг зохих журмын дагуу олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулсан бөгөөд БНХАУ-аас оруулж ирэх техник, тоног төхөөрөмжүүд болон инженер техникийн ажиллагсадыг үе шаттайгаар оруулж ирэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.</p> <p>Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ 202.4 км авто замын Төслийн зам барилгын ажлыг 5 багц хэсгээр хэрэгжилтийг зохион байгуулж байна.</p> <p>Багц 1-5 хэсгийн барилгын 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс эхлүүлсэн. Нийт 5 багц хэсгийн барилгын ажлын гүйцэтгэл: Багц 1 хэсэг 85,7 хувь, багц 2 хэсэг 47 хувь, багц 3 хэсэг 45 хувь, багц 4 хэсэг 60 хувь, багц 5 хэсэг 62 хувийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжиж байна. Нийт хэрэгжилт 60 хувийн гүйцэтгэлтэй байна.</p>
2	Өмнөговь аймгийн Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 477.1 км тусгай зориулалтын авто замын төсөл (2020-2023 он)	<p>Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл хийгдсэн.</p> <p>Засгийн газрын 2019 оны 238 дугаар тогтоолын дагуу Үндэсний хөгжлийн газраас “Тахилт хайрхан транс” ХХК-тай концессын гэрээг байгуулсан бөгөөд 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр гэрээ хүчин төгөлдөр болсон. Зам барилгын ажлыг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр эхлүүлсэн.</p> <p>COVID-19 цар тахлын улмаас ажиллах хүч, техник тоног төхөөрөмж хилээр нэвтрүүлэх асуудал удааширч барилга угсралтын ажил анх төлөвлөснөөс 1 жилээр хоцрогдож байна.</p> <p>"Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто замын төсөл"-ийн талаар мэдээлэл бэлтгэж, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний хуралдаанд танилцуулсан.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн сайд 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр концесс, эзэмшигч, гүйцэтгэгчийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, зам барилгын ажилд учирч буй саадыг шийдвэрлүүлэх асуудлын талаар ярилцаж, зам</p>

		барилгын ажлыг эрчимжүүлэх талаар үүрэг даалгавар, чиглэл өгсөн. 2022 оны зам барилгын ажлыг 03 дугаар сарын 15-ны өдөр эхлүүлсэн. Ажлын талбайд 819 хүн хүч, 582 машин, техник тоног төхөөрөмж байршин, хэмжилт, далангийн дүүргэлт, суурийн доод үе, хиймэл байгууламж, чулуу бутлах ажил гүйцэтгэсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 42 хувьтай байна.
Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл		
3	Ханги боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл (2020-2023 он)	Ханги боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийг шат дараатайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд тус төслийн хүрээнд Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замыг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ашиглалтад хүлээж аваад байна. Түүнчлэн Зам, тээврийн хөгжлийн сайд 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр концесс, эзэмшигч, гүйцэтгэгчийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, зам барилгын ажилд учирч буй саад, шийдвэрлүүлэх асуудлын талаар ярилцаж, зам барилгын ажлыг эрчимжүүлэх талаар үүрэг даалгавар, чиглэл өгсөн. 2022 оны зам барилгын ажлыг 03 дугаар сарын 15-ны өдөр эхлүүлсэн. Ажлын талбайд 819 хүн хүч, 582 машин, техник тоног төхөөрөмж байршин, хэмжилт, далангийн дүүргэлт, суурийн доод үе, хиймэл байгууламж, чулуу бутлах ажил гүйцэтгэсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 42 хувьтай байна.

“Хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувьтай 10 төсөл арга хэмжээ:

Хүснэгт 4

№	Төсөл арга хэмжээ	Хэрэгжилт
Төмөр замын төслүүд		
1	Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр замын төсөл (2022-2024 он)	Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдөр хуралдаж, тус чиглэлийн төмөр замын төсөлд 2 компанитай хэлцэл хийхийг даалгасны дагуу тус чиглэлийн төсөлд “Ийст коридор рэйлрөөд” ХХК, “Бодь интернэшнл” ХХК-тай уулзалт хийж, эхний ээлжинд эдгээр компаниудаас хэрхэн хамтран ажиллах талаар саналуудыг бичгээр хүлээн авч дахин санал солилцохоор тохиролцсон. Төслийн сонгон шалгаруулалтад санал өгсөн оролцогч байгууллагаас гомдол гарсан тул шүүхийн шатанд хянагдаж байна.
2	Гашуунсухайт-Ганцмод боомтуудыг төмөр замаар холбох төсөл 7.9км (2022 он)	“Тавантолгой төмөр зам” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК болон БНХАУ-ын “Чайна Энержи” ХХК-иас “Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам болон нүүрс худалдах, худалдан авах талаар хамтран ажиллах ерөнхий хэлэлцээр”-ийг 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдөр талууд цахимаар гарын үсэг зурж баталгаажуулсан. Хятадын зураг төслийн групп нь Монголын талд технологийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ТЭЗҮ, ажлын нарийвчилсан зураг төслийг боловсруулахтай холбогдуулан техникийн зөвлөх үйлчилгээний гэрээний төсөл болон ажлын даалгавар, ТЭЗҮ, нарийвчилсан зураг төслийн нийт үнийн саналыг тус тус ирүүлсэн. Энэ хүрээнд хил холболтын төмөр замын ТЭЗҮ, барилгын ажлын

		нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын санхүүжилт болон тухайн ажлыг 2023 оны 02 дугаар улиралд эхлүүлэх талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхээр 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр нууцын асуудлаар хүргүүлсэн. Хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах асуудлыг шийдвэрлүүлэхээр 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн н08/31 дугаар албан бичгээр танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт дахин хүргүүлсэн. Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтыг төмөр замаар холбох төслийн техник, эдийн засгийн үндэслэл, ажлын нарийвчилсан зураг төсөл боловсруулах асуудлыг танилцуулж шийдвэрлүүлсэн.
3	Сүхбаатар-Замын-Үүд чиглэлийн төмөр замын төв коридорыг хос замтай болгох, шинэчлэх төсөл 269 км (2022-2025 он)	Энэхүү төслийн бүтээн байгуулалтыг “Улаанбаатар төмөр зам” ХНН хариуцан гүйцэтгэх бөгөөд Замын-Үүд – Шаргын-Овоо хоорондын 14.26 км хоёрдох гол замын ТЭЗҮ-ийг боловсруулсан. Замын-Үүд өртөө, Шаргын-Овоо зөрлөг болон хоорондын замд хоёр дахь гол зам барих газар сонголтыг хийж, зураг төсөл бэлэн болсон. 2022 оны 05 дугаар сард нээлттэй сонгон шалгаруулалт зарласан бөгөөд нийт 9 багц 80 гаруй ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгааны ажлууд болон зураг төсөл бүрэн хийгдсэн, Байгаль орчны нөлөөллийн байдлын үнэлгээ боловсруулах, Инженер-геологийн ажлын гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж мөн газар шорооны ажлыг хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийг нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулж төслийн талбайд барилгын ажлыг эхлүүлсэн. 2022 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар доод бүтцийн ажлын туслан гүйцэтгэгчээр шалгарсан “Их харгуйн зам” ХХК нь 1700 м3 хөрс хуулалт хийсэн, 5000 м3 далангийн ажил хийгдсэн. Төслийн доод бүтцийн ажил 100 хувь, Бетон дэр үйлдвэрлэлт-100 хувь, Зам төмөр татан авалт-30 хувь, Зам төмөр дэрийн сараалжийг угсрах-5.3 хувийн гүйцэтгэлтэй байна.
4	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын Гашуунсухайт боомт дахь шилжүүлэн ачих байгууламж барих төсөл (2022-2023 он)	2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 24.3 хувьтай байна. Үүнд: газар шорооны ажил- 100 хувь, хоолойн ажил - 100 хувь, Дээд бүтцийн үйлдвэрлэл, барилга угсралтын ажил - 100 хувь, чингэлгийн талбайн болон авто талбай 0, Эрчим хүч-0, дохиолол төвлөрүүлэлт холбооны байгууламжийн угсралт, суурилуулалт-0, шилжүүлэн ачих терминалын барилга байгууламж-0. Гашуунсухайт боомт дахь шилжүүлэн ачих байгууламжийн төмөр замын барилгын ажил бүрэн дууссан бөгөөд улирлын байдлаас шалтгаалан терминалын барилга угсралтын ажил одоогоор зогссон байна.
Авто замын төсөл		
5	Норовлин-Баян-Уул-Ульхан чиглэлийн 121 км хатуу хучилттай авто замын төсөл Норовлин-Баян-Уул-Ульхан боомт хүртэлх 118.3 км хатуу хучилттай авто замын төсөл /68.3+50/ (2022-2025 он)	Замын барилгын ажлыг 2 багц болгон худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: Багц 1 буюу Норовлин-Баян-Уул чиглэлийн 68.3 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зарлаж, үнэлгээ хийн шалгарсан "Монгол зам групп" болон "Голд өлзийт" компанийн түншлэлтэй 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр гэрээ байгуулж, зам барилгын ажлыг эхлүүлсэн. Ажлын явц 8,2 хувьтай үргэлжилж байна. Багц 2 буюу Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх 50 км хатуу хучилттай авто замын барилгын ажил гүйцэтгэх гүйцэтгэгчийг

		сонгон шалгаруулах тендерийг 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн 2 удаа нээлттэй, 3 удаа шууд гэрээ байгуулахаар зарласан боловч "Нэг ч оролцогч санал ирүүлээгүй", "Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй", "Тендер хүчинтэй хугацаанд багтаан гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй" зэрэг шалтгаанаар амжилтгүй болсон. Уг ажлын магадлалын дүгнэлтээр баталгаажсан төсөвт өртөг нь улсын төсвийн тухай хуульд тусгагдсан дүнгээс ихээхэн зөрүүтэй байсан ба төсөвт өртгийг шинэчилж, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд шинэчлэгдсэн дүнгээр санхүүжилтыг тусгуулахаар саналаа Сангийн яаманд хүргүүлж, батлуулсан. Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан тендерийг дахин зарлахаар бэлтгэж байна.
Нисэх онгоцны буудлын төслүүд		
6	Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг 4С ангиллын болгох төсөл (2022-2024 он)	Зурвасын ажлын зураг 2019 онд, зорчигч үйлчилгээний цогцолборын ажлын зураг 2020 онд хийгдсэн. Зам, тээврийн хөгжлийн төвөөр хянагдсан ажлын хяналтын төсөв 49,9 тэрбум, нисэх буудлын тоног төхөөрөмжүүдийг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт 3 тэрбум, нийт 52,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай.
7	Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж олон улсын 4С ангиллын болгох төсөл (2022-2024 он)	Зурвасын ажлын зураг 2010 онд хийгдсэн. Зам, тээврийн хөгжлийн төвөөр хянагдсан ажлын хяналтын төсөв 18,9₮ тэрбум, зорчигч үйлчилгээний цогцолборын барилгын ажлын зураг боловсруулахад 270 сая, нисэх буудлын барилга, нислэг хөдөлгөөний хяналтын цамхаг, бусад инженерийн байгууламжийн шинэчлэхэд 20 тэрбум, тоног төхөөрөмж шинэчлэхэд 3 тэрбум, нийт 42,17 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай.
8	Дорнод аймгийн "Чойбалсан" нисэх буудлыг 4С ангиллын болгох төсөл (2022-2024 он)	Эдийн засаг, хөгжлийн яамтай зөвшилцсөний дүнд "Жайка" Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын "Монгол Улсын Хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавхыг бэхжүүлэх төсөл"-д тус нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгох төслийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, холбогдох судалгаа тооцоог хамтран хийхээр тогтож, ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.
9	Өмнөговь аймгийн "Гурвансайхан" нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж 4D ангиллын болгох төсөл (2022-2024 он)	ТЭЗҮ, барилга байгууламжийн иж бүрэн зураг төслийг "Эрхэс Констракшн" ХХК боловсруулж байна. Орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг Барилга, хот байгуулалтын сайд (ТЕЗ)-ын төсвийн "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улсын хэмжээнд)"-т тусган санхүүжилтийг шийдвэрлэх хүсэлт Сангийн яаманд хүргүүлсэн. (2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 01/4549) Нисэх буудлыг концессын зүйлийн "Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж байна.
Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүд		
10	Алтанбулаг боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл (2022-2025 он)	Тус яам нь БНСУ-ын Сангийн яам, Худалдаа, хөрөнгө оруулалтын агентлаг (KOTRA)-тай хамтран ажиллаж, Мэдлэг хуваалцах хөтөлбөрийн хүрээнд техникийн туслалцааны төслөөр Алтанбулаг тээвэр, логистикийн төвийг байгуулах урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлэв. Төслийн гүйцэтгэгчээр БНСУ-ын барилгын зураг төслийн SAMOOC.M. компани ажилласан ба

	төслийн эцсийн шатны тайланг 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдөр хэлэлцүүлэн хүлээн авч тайланг хэвлэлтэд өгсөн. 2022 онд Алтанбулаг тээвэр, логистикийн төвийг байгуулах урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсан.
--	--

“Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” 17 төсөл, арга хэмжээ:

Хүснэгт 5

№	Төсөл арга хэмжээ	Хэрэгжилт
Төмөр замын төслүүд		
1	Эрээнцав-Баянтүмэн /Чойбалсан/ чиглэлийн төмөр замыг шинэчлэх төсөл 268 км (2023-2024 он)	Эрээнцав-Баянтүмэн төмөр замд өргөтгөл шинэчлэлт хийх техникийн урьдчилсан тооцооллыг хийсэн. Тулгамдаж буй асуудал: “УБТЗ” ХНН-ийн хувь нийлүүлэгчдийн хурлаар санхүүжилтийг шийдвэрлэх Шийдэл: Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж, ажлын явцын нарийвчилсан төлөвлөгөө гаргах ажлыг “УБТЗ” ХНН хариуцах.
2	Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1255 км төмөр замын төсөл (2025-2030 он)	Баруун чиглэлийн төмөр замын төсөлд 4 санал ирсэнээс Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдөр хуралдаж компанитай хэлцэл хийхийг даалгасан. “Эссенз Саплайз” ХХК-тай уулзалт хийж, эхний ээлжинд эдгээр компаниудаас хэрхэн хамтран ажиллах талаар саналуудыг бичгээр хүлээн авч дахин санал солилцохоор тохиролцсон. Төслийн сонгон шалгаруулалтад санал өгсөн оролцогч байгууллагаас гомдол гарсан тул шүүхийн шатанд хянагдаж байна. Тулгамдаж буй асуудал: Концессын сонгон шалгаруулалттай холбоотой шүүхэд маргаан гарсан. Шийдэл: Концессын сонгон шалгаруулалтын ажлыг дахин нягталж шүүхийн маргаантай асуудлыг шийдвэрлүүлэх
3	Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 395 км төмөр замын төсөл (2023-2026 он)	БНСУ-ын санхүүжилтээр тус чиглэлийн урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажлын судалгаа шинжилгээ, материал цуглуулах ажил хийгдсэн. Сонгогдсон чиглэлд төмөр замын 2 трассын дагуу газарзүйн судалгааны ажлыг Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газартай хамтран төслийн инженерийн судалгаа хийж буй Юушин Инженеринг Корпораци 1:50000 масштабтай трассын судалгаа хийж байна. Төслийн ТЭЗҮ боловсруулахтай холбогдуулан Солонгосын төмөр замын корпорацийн Тээвэр, хөдлөх бүрэлдэхүүн хариуцсан газрын дарга Чон Юун Хван, Гадаад хамтын ажиллагааны мэргэжилтэн И Жун Юн нартай 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр уулзалт хийж, ТЭЗҮ-ийн галт тэрэгний ашиглалт, үйл ажиллагааны хэсгийн тайлан боловсруулахад шаардлагатай мэдээлэл авсан. Сайншанд- Баруун-Урт- Хөөт, Тавантолгой -Даланзадгад чиглэлийн төмөр замуудын ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр БНСУ-ын тээврийн хүрээлэн, Солонгосын Гео Шинжлэх Ухаан ба Эрдэс баялгийн нөөцийн хүрээлэн, Зам, тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Үндэсний геологийн алба, МУИС, ШУТИС-ын төлөөлөл Уул уурхайн бүтээгдэхүүн ба төмөр замаар ачаа тээвэрлэх, логистикийн төв байгуулах тухай

		<p>семинарыг зохион байгуулж, харилцан санал солилцож, хэлэлцүүлэг хийсэн. Төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийг 2023 оны 06 дугаар сард дуусгахаар төлөвлөж байна.</p> <p>Тулгамдаж буй асуудал: ТЭЗҮ, зураг төслийг дуусгах, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх.</p> <p>Шийдэл: Эдийн засаг, хөгжлийн яам, Боомтын сэргэлтийн үндэсний хороотой хамтарсан нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, батлуулах.</p>
Авто замын төслүүд		
4	<p>Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн 997 км хурдны авто замын төсөл (2025-2030 он)</p>	<p>Бэлтгэл ажлын хүрээнд:</p> <p>Концесс эзэмшигчээр шалгарсан “Чингис лэнд девелопмент групп-Шинэ хөгжлийн зам” ХХК-тай 2014 онд концессын гэрээ байгуулсан боловч гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөлүүдийг хангаагүй шалтгаанаар Засгийн газрын 2015 оны 158 дугаар тогтоолоор концессын гэрээг цуцалсан. Замын-Үүд-Алтанбулаг олон улсын транзит хурдны замын төслийг 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар танилцуулсан. Хуралдаанаас уралдаант шалгаруулалтыг яаралтай зарлах үүрэг даалгавар өгөгдсөн. Чиг үүргийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газраас “Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны авто зам төсөл”-ийн концесс олгох уралдаант шалгаруулалтын баримт бичгийг боловсруулах, үнэлэх, гэрээний хэлцэл хийх ажлын хэсэг байгуулахаар тус яамнаас Ажлын хэсэгт ажиллах албан тушаалтны нэрийг авсан. ЗГХЭГ-аас концесс, төрийн хувийн хэвшлийн чиг үүргийг ЭЗХЯ хариуцах болсонтой холбогдуулан Төрийн худалдан авах ажиллагааны газарт буй төслүүдийн мэдээллийг хүлээлцэх хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаатай холбогдуулан ажлын хэсэг байгуулах ажил түр хойшлогдсон байна.</p> <p>Концесс, төр-хувийн хэвшлийн түншлэлийн чиг үүрэг Төрийн худалдан авах ажиллагааны газраас Эдийн засаг, хөгжлийн яаманд шилжсэнтэй холбогдуулан тус яамнаас Эдийн засаг, хөгжлийн яаманд 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1712 тоот албан бичгээр концесс олгох уралдаант шалгаруулалтыг зарлах ажлыг яаравчлан, хамтран ажиллах талаар хүсэлт хүргүүлсэн. Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 27 дугаар тэмдэглэлээр “Концессын төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын баримт бичгийг хамтран боловсруулахыг Эдийн засаг, хөгжлийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газарт даалгав” гээд Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтсон байна. Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор концесс олгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт даалгасан. 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдөр ажлын хэсэг хуралдаж, Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад "Барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр тусгагдсаныг хуульд нийцүүлэх "Зураг төсөл</p>

		<p>боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрөл болгон Концессын зүйлийн жагсаалтад өөрчлөлт оруулсны дараа уралдаант шалгаруулалт зарлахаар шийдвэрлэсэн. Эдийн засаг хөгжлийн яамнаас 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 03/1081 тоотой Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан төрлөөр нь уралдаант шалгаруулалтыг шуурхай зохион байгуулах арга хэмжээ авах зөвлөмжийг ажлын хэсэгт хүргүүлсэн. Ажлын хэсэг урьдчилсан уралдаант шалгаруулалтын баримт бичгийг боловсруулан урилгыг 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болон үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, UB post хэвлэлд нийтэлсэн. Урьдчилсан сонгон шалгаруулалтын саналыг 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр хүртэл хүлээн авна.</p> <p>Хүлээгдэж буй ажлууд: Урьдчилсан сонгон шалгаруулалтын саналыг хүлээн авч үнэлэх, уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах ажлууд хүлээгдэж байна.</p> <p>Шийдэл: Гадаадын зээл, тусламж, Төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар санхүүжилтийг шийдвэрлэх.</p>
5	<p>Нөмрөг-Арцсуурь чиглэлийн 159.5 км хатуу хучилттай авто замын төсөл (2024-2028 он)</p>	<p>Бэлтгэл ажлын хүрээнд: Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2021 онд "Аварга зам" ХХК хийж гүйцэтгэсэн. Хилийн боомт чиглэлийн авто замын төслүүдийн мэдээллийг бэлтгэж, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаас хилийн боомтуудыг холбох хөрөнгө оруулалт нь тодорхойгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээ байгуулах замаар шийдвэрлэх боломжтой эсэхийг судлан санал танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллууж, саналыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхланд даалгасан. Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан төслүүдийн явц байдлын талаар хуваарь гарган, Засгийн газрын хуралдаанд танилцуулах шийдвэрийн дагуу уг төслийн талаарх мэдээллийг бэлтгэн, санхүүжилтийг шийдвэрлэх саналын хамт 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг тусгуулахаар саналаа тусган хүргүүлсэн боловч тусгагдаагүй. Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлэх 4-р шатны ажлын хүрээнд тус авто зам барих санал гарган Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Тулгамдаж буй асуудлууд: 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг тусгуулахаар саналаа тусган хүргүүлсэн боловч тусгагдаагүй.</p>

		<p>Шийдэл: Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлэх 4-р шатны ажлын хүрээнд тус авто зам барих санал гарган Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.</p>
6	<p>Алтай-Бургастай чиглэлийн 320 км авто замын төсөл (2025-2030 он)</p>	<p>Бэлтгэл ажлын хүрээнд: Хилийн боомт чиглэлийн авто замын төслүүдийн мэдээллийг бэлтгэж, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаас хилийн боомтуудыг холбох хөрөнгө оруулалт нь тодорхойгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээ байгуулах замаар шийдвэрлэх боломжтой эсэхийг судлан санал танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, саналыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхланд даалгасан. 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд эхний ээлжийн 100 км замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг тусгуулахаар саналаа хүргүүлсэн боловч тусгагдаагүй. 2023 оны Улсын төсвийн тухай хуулийн Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад ТЭЗҮ, зураг төсөл боловсруулахад шаардлагатай хөрөнгө тусгагдсан тул тус чиглэлийн авто замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах санхүүжилтийг тусгуулах санал хүргүүлсэн.</p> <p>Тулгамдаж буй асуудлууд: 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд эхний ээлжийн 100 км замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг тусгуулахаар саналаа хүргүүлсэн боловч тусгагдаагүй.</p>
7	<p>Хатгал-Ханх чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замын төсөл (2023-2025 он)</p>	<p>Бэлтгэл ажлын хүрээнд: ТЭЗҮ, зураг төсөл хийгдээгүй, зам барилгын ажилд ойролцоогоор 225.0 тэрбум төгрөг шаардлагатай, зураг төсвөөр эцэслэн тодорхойлогдоно. Хилийн боомт чиглэлийн авто замын төслүүдийн мэдээллийг бэлтгэж, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаас хилийн боомтуудыг холбох хөрөнгө оруулалт нь тодорхойгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээ байгуулах замаар шийдвэрлэх боломжтой эсэхийг судлан санал танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, саналыг 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхланд даалгасан. Хатгал-Ханх чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замын зураг төслийг боловсруулах хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр 2023 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгуулахаар саналаа Сангийн яаманд хүргүүлсэн боловч тусгагдаагүй.</p>

		<p>Тулгамдаж буй асуудлууд: Эхний ээлжинд зураг төслийг боловсруулах, зураг төсөлтэй болсны дараа 2024 оны Улсын төсөвт тусгуулах саналыг Сангийн яаманд хүргүүлж ажиллана.</p> <p>Шийдэл: Гадаадын зээл, тусламж, Төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар санхүүжилтийг шийдвэрлэх.</p>
8	Чойбалсан-Баянхошуу хилийн боомтын чиглэлийн 198.2 км авто замын төсөл (2027-2030 он)	<p>Бэлтгэл ажлын хүрээнд: Монгол Улсын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны захиалгаар “Эм Си Пи Си Жи АР” ХХК Чойбалсан-Халхгол сум-Сүмбэр боомт чиглэлийн авто замын Техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааг 2011 онд хийсэн.</p> <p>Тосон-Уул-Баянхошуу чиглэлийн 210.7 км хатуу хучилттай авто замын 4 замын уулвараас Халхгол сум хүртэлх 67.06 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг 2016 онд “Ай Си Ти Сайн Консалтинг” ХХК хийж гүйцэтгэсэн.</p> <p>Одоогийн ханшаар ойролцоогоор 190 тэрбум төгрөг шаардлагатай.</p> <p>Хилийн боомт чиглэлийн авто замын төслүүдийн мэдээллийг бэлтгэж, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.</p> <p>Хуралдаанаас хилийн боомтуудыг холбох хөрөнгө оруулалт нь тодорхойгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээ байгуулах замаар шийдвэрлэх боломжтой эсэхийг судлан санал танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, саналыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхланд даалгасан.</p> <p>Хүлээгдэж буй ажлууд: Зам барилгын ажилд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх.</p> <p>Тулгамдаж буй асуудлууд: Дараах ажлууд хүлээгдэж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Зам барилгын ажлыг хэрэгжүүлэх хугацааг тодорхой болгох; 2. Ажлын зураг, төсвийг шинэчлэх. <p>Шийдэл: Гадаадын зээл, тусламж, Төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар санхүүжилтийг шийдвэрлэх.</p>
9	Дорнод аймгийн Тосон-Уул-Баянхошуу чиглэлийн замын Өмнөд Буйрын 4 замын уулзвараас Халхгол сум-Сүмбэр боомт чиглэлийн 152.6 км хатуу хучилттай авто замын төсөл (2027-2030 он)	<p>Бэлтгэл ажлын хүрээнд: Монгол Улсын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны захиалгаар “Эм Си Пи Си Жи АР” ХХК Чойбалсан-Халхгол сум-Сүмбэр боомт чиглэлийн авто замын ТЭЗҮ-ийн урьдчилсан судалгааг 2011 онд хийсэн.</p> <p>Тосон-Уул-Баянхошуу чиглэлийн 210.7 км хатуу хучилттай авто замын 4 замын уулвараас Халхгол сум хүртэлх 67.06 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг 2016 онд “Ай Си Ти Сайн Консалтинг” ХХК хийж гүйцэтгэсэн.</p> <p>Халхгол сумаас Сүмбэр боомт хүртэлх 85 км замын зураг төсөл хийгдээгүй.</p> <p>Замын барилгын ажлын төсөв ТЭЗҮ, нарийвчилсан</p>

		<p>зураг төслөөр эцэслэн тодорхойлогдоно. Одоогийн ханшаар ойролцоогоор 170 тэрбум төгрөг шаардлагатай.</p> <p>Хилийн боомт чиглэлийн авто замын төслүүдийн мэдээллийг бэлтгэж, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.</p> <p>Хуралдаанаас хилийн боомтуудыг холбох хөрөнгө оруулалт нь тодорхойгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээ байгуулах замаар шийдвэрлэх боломжтой эсэхийг судлан санал танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, саналыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхланд даалгасан.</p> <p>Хүлээгдэж буй ажлууд: Зам барилгын ажилд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх.</p> <p>Тулгамдаж буй асуудлууд: Халхгол сумаас Сүмбэр боомт хүртэлх 85 км замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх, зураг төслийг боловсруулах ажлууд хүлээгдэж байна.</p> <p>Шийдэл: Гадаадын зээл, тусламж, Төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар санхүүжилтийг шийдвэрлэх.</p>
10	<p>Булган аймгийн Хутаг-Өндөр сумаас Бага-Илэнхи боомт хүртэлх 131.27 км хатуу хучилттай авто замын төсөл (2029-2032 он)</p>	<p>Бэлтгэл ажлын хүрээнд:</p> <p>Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2012 онд "Ай Си Ти Сайн Консалтинг" ХХК хийж гүйцэтгэсэн. Төсөвт өртөг 121 тэрбум төгрөг, замын төсөв 2012 онд хийгдсэн тул төсвийг шинэчлэх шаардлагатай, одоогийн ханшаар тооцож үзвэл ойролцоогоор 165 тэрбум төгрөг болж байна.</p> <p>Хилийн боомт чиглэлийн авто замын төслүүдийн мэдээллийг бэлтгэж, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.</p> <p>Хуралдаанаас хилийн боомтуудыг холбох хөрөнгө оруулалт нь тодорхойгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээ байгуулах замаар шийдвэрлэх боломжтой эсэхийг судлан санал танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, саналыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхланд даалгасан.</p> <p>Хүлээгдэж буй ажлууд: Зам барилгын ажилд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх.</p> <p>Тулгамдаж буй асуудлууд: Дараах ажлууд хүлээгдэж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Зам барилгын ажлыг хэрэгжүүлэх хугацааг тодорхой болгох; 2. Ажлын зураг, төсвийг шинэчлэх; 3. Зам барилгын ажилд шаардлагатай хөрөнгө оруулалтыг Улсын төсөвт үе шаттайгаар тусгуулах. <p>Шийдэл: Гадаадын зээл, тусламж, Төрийн болон</p>

		хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар санхүүжилтийг шийдвэрлэх.
11	Увс аймгийн Улаангом сумаас Тэс боомт хүртэлх 220 км авто замын төсөл	<p>Бэлтгэл ажлын хүрээнд: Хилийн боомт чиглэлийн авто замын төслүүдийн мэдээллийг бэлтгэж, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаас хилийн боомтуудыг холбох хөрөнгө оруулалт нь тодорхойгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээ байгуулах замаар шийдвэрлэх боломжтой эсэхийг судлан санал танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, саналыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхланд даалгасан.</p> <p>Хүлээгдэж буй ажлууд: ТЭЗҮ боловсруулах, санхүүжилтийг шийдвэрлүүлэх.</p> <p>Тулгамдаж буй асуудлууд: Дараах ажлууд хүлээгдэж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Зам барилгын ажлыг хэрэгжүүлэх хугацааг тодорхой болгох; 2. Ажлын зураг, төсвийг шинэчлэх. <p>Шийдэл: Гадаадын зээл, тусламж, Төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар санхүүжилтийг шийдвэрлэх.</p>
Нисэх онгоцны буудлын төслүүд		
12	Увс аймгийн "Дэглийцагаан" нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж 4С ангиллын болгох төсөл (2024-2026 он)	<p>Зурвасын ажлын зураг 2020 онд, зорчигч үйлчилгээний цогцолборын барилгын ажлын зураг 2021-2022 онд хийгдсэн. Зам, тээврийн хөгжлийн төвөөр хянагдсан зурвасын ажлын хяналтын төсөв 61,07 тэрбум, зорчигч үйлчилгээний барилгын өргөтгөлийн ажлын хяналтын төсөв Барилгын хөгжлийн төвөөр хянагдаж байна, урьдчилсан байдлаар 6,57 тэрбумын хяналтын төсөв, нисэх буудлын тоног төхөөрөмж шинэчлэхэд 3 тэрбум, нийт 70,573 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай.</p> <p>Шийдэл: Гадны зээл, тусламжаар хэрэгжүүлэх боломжгүй байгаа тул төр, хувийн хэвшлийн түншлэлээр шийдвэрлэх</p> <p>Тулгамдаж буй асуудал: Концессын үр ашгийн тооцооллыг Төрийн өмчийн хорооны 2010 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 153 дугаар тогтоолоор баталсан "Концессын зүйлийн зардал, үр ашгийн тооцоо хийх түр аргачлал"-ын дагуу боловсруулсан бөгөөд урьдчилсан тооцооллын үр дүнгээр уг төслийн NPV/Цэвэр өнөөгийн үнэ цэнэ -70.7 тэрбум төгрөг байна. Зорчигч урсгалын тоо бага, хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр зэргээс шалтгаалж, алдагдалтай байна.</p> <p>Эдийн засаг, хөгжлийн яам төслийн цэвэр өнөөгийн үнэ цэнэ 0-ээс бага байгаа тул концессын жагсаалтад оруулах боломжгүй байгаа талаар мэдээлсэн.</p> <p>Шийдвэрлэх санал:</p> <ol style="list-style-type: none"> 1.Төр, хувийн хэвшлийн түншлэл буюу концессын зүйлийг амжилттай хэрэгжүүлэхийн тул дараах арга

		<p>хэмжээг авах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Агаарын навигацийн үйлчилгээнд хамаарагдах үйл ажиллагаа болон холбогдох зардлыг ИНЕГ хариуцах; • Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой шаардлагатай тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх; • Тухайн аймгийн олон улс болон орон нутгийн нислэгийн тогтмолжилтыг бодлогоор дэмжиж ажиллах, шаардлагатай нөхцөлд нөхөн төлбөр олгох; • Төрөөс үзүүлж буй бүх төрлийн татвар, хураамжаас чөлөөлөх. <p>2. “Дэглий цагаан” нисэх буудлын зорчигч урсгал тогтворжсоны дараа хувийн хэвшилд үе шаттайгаар шилжүүлэх</p>
13	Олон улсын ачаа тээврийн транзит төв болгох төсөл (2026-2028 он)	<p>Үндэсний хөгжлийн газар, “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК хооронд 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээний 19.1-т “Концесс эзэмшигч нь үйл ажиллагаа эхлэх өдрөөс хойш 2 жилийн дотор концессын хугацааг бүхэлд нь хамарсан нисэх буудлын мастер төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдэд танилцуулна” гэж заасны дагуу Нисэх буудлын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх ажлыг 2023 оны 06 дугаар сард багтаан танилцуулах чиглэлийг Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-д өгсөн.</p> <p>Тулгамдаж буй асуудал: “Чингис хаан” ОУНБ-ын мастер төлөвлөгөө боловсруулах санхүүжилтийг 2022 онд шийдвэрлэх шаардлагатай.</p> <p>Шийдэл: НУБИА-тай концессын гэрээний хүрээнд хамтран ажиллах шийдэл гаргах.</p>
14	“Чингис хаан” олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг өргөтгөх төсөл (2026-2028 он)	<p>Үндэсний хөгжлийн газар, “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК хооронд 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээний 19.1-т “Концесс эзэмшигч нь үйл ажиллагаа эхлэх өдрөөс хойш 2 жилийн дотор концессын хугацааг бүхэлд нь хамарсан нисэх буудлын мастер төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдэд танилцуулна” гэж заасны дагуу Нисэх буудлын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх ажлыг 2023 оны 06 дугаар сард багтаан танилцуулах чиглэлийг Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-д өгсөн.</p> <p>Тулгамдаж буй асуудал: “НУБИЭ” ХХК-иас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн РС-АР/163 тоот албан бичгээр нислэгийн тоо, зорчигч урсгал бага, нисэх буудлын хүчин чадлыг бүрэн ашиглахгүй байгаа, ОУАТХ (IATA)-ноос гаргасан “Агаарын тээврийн статистик үзүүлэлт 2024 он гэхэд 2019 оны түвшинд хүрэх” таамаглал зэрэгт үндэслэн одоогоор нисэх буудлыг өргөжүүлэх хэрэгцээ шаардлага байхгүй бөгөөд эхний ээлжид одоогийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх саналыг ирүүлээд байна.</p> <p>Шийдэл: НУБИА-тай концессын гэрээний хүрээнд хамтран ажиллах шийдэл гаргах.</p>

Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүд		
15	Бичигт боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл (2023-2025 он)	<p>“Бичигт боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Бичигт хилийн боомтод ачаа тээврийн терминал байгуулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч Хилийн боомтын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх чиглэл өгсний дагуу Хилийн боомтын үндэсний зөвлөлд хүргүүлсэн.</p> <p>Хүлээгдэж буй ажлууд: Уг асуудлыг Хилийн боомтын үндэсний зөвлөлөөр яаралтай хэлэлцүүлэх шаардлагатай байна.</p> <p>Тулгамдаж буй асуудал: Зураг төсөл, ТЭЗҮ-байхгүй.</p> <p>Шийдэл: Эдийн засаг, хөгжлийн яам, Боомтын сэргэлтийн үндэсний хороотой хамтарсан нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, батлуулах.</p>
16	Эрэнцав боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл (2023-2024 он)	<p>Эрэнцав-Баянтүмэн төмөр замд өргөтгөл шинэчлэлт хийх техникийн урьдчилсан тооцооллыг хийсэн. Монгол-Орос Улсын Засгийн газрын хэлэлцээрээр Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгийн дүрмийн сан нэмэгдүүлсний дараа уг төслийг хийж хэрэгжүүлнэ.</p> <p>Хүлээгдэж буй ажлууд: Эрэнцав-Баянтүмэн төмөр замд өргөтгөл шинэчлэлт хийх төслийн хүрээнд хэрэгжүүлнэ.</p> <p>Тулгамдаж буй асуудал: Зураг төсөл, ТЭЗҮ-байхгүй.</p> <p>Шийдэл: Эдийн засаг, хөгжлийн яам, Боомтын сэргэлтийн үндэсний хороотой хамтарсан нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, батлуулах.</p>
17	Арцсуурь боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл (2024-2026 он)	<p>Баруун босоо чиглэлийн төмөр замын төслийн концессын уралдаант шалгаруулалт явагдаж байгаа ба тус төслийн хүрээнд уг төслийг хэрэгжүүлнэ.</p>

Зам, тээврийн хөгжлийн яамнаас үл хамаарах шалтгаантай 3 төсөл, арга хэмжээ нь:

Хүснэгт 6

№	Арга хэмжээ	Хэрэгжилт
Авто замын төслүүд		
1	Хавирга хилийн боомт чиглэлд: Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто замын төсөл Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто замын төсөл (2022-2025 он).	<p>Хүлээгдэж буй арга хэмжээ:</p> <p>“Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 124.5 км /Дорнод/”-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж байгаа бөгөөд тендерийг 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр тендерийг зарлаж, 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр нээсэн.</p> <p>Сонгон шалгаруулалтад нэг хуулийн этгээд саналаа ирүүлсэн боловч тендерийн баримт бичигт шаардсан нөхцөл шаардлагыг хангаагүйн улмаас тендер хүчингүй болсон байна.</p> <p>Дахин зарласан боловч шаардлага хангасан тендер ирүүлээгүй тул хуулийн дагуу 3 дахь удаагаа зарлаад байна. Тендерийг 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр нээсэн боловч тендер амжилтгүй болсон. 2022 оны Улсын төсөвт 2016 онд батлагдсан зам барилгын ажлын төсөвт өртгөөр суугдсан тул төсөвт дахин магадлал оруулж (2022 оны бараа материалын үнийн дүнгээр) 2023 оны Улсын төсөвт суулган, баталсан.</p> <p>Хүлээгдэж буй ажлууд: Хавиргын боомт чиглэлийн 124.5 км авто замыг олон багцад хуваахаар зураг төслийг салгах ажил хийгдэж байна.</p> <p>Тулгамдаж буй асуудлууд: Зам барилгын төсөвт өртөг хэтэрхий</p>

		<p>бага тул сонирхсон оролцогч орж ирэхгүй байгаа тул төсөвт өртгийг нэмэгдүүлэх шаардлагатай. Хавиргын боомт чиглэлийн 124.5 км авто замыг олон багцад хуваахаар зураг төслийг салгах ажил хийгдэж байна.</p> <p>Шийдэл: Төрийн худалдан авах ажиллагааны газраас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг шуурхай зохион байгуулах.</p>
2	<p>Цагаан дэл уул хилийн боомт чиглэлд: Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл Уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замын төсөл (2020-2023 он).</p>	<p>Хүлээгдэж буй арга хэмжээ:</p> <p>Концессын гэрээ 2019 онд хүчин төгөлдөр болж зам барилгын ажил эхлүүлэх боломж бүрдсэн боловч орон нутгаас авто замын зурвас газар эзэмшүүлэх зөвшөөрөл олгогдоогүй шалтгаанаар төслийн ажил зогсонги байдалтай байсан. Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн "Газар эзэмших эрх олгох тухай" А/05 дугаар захирамж гарснаар тухайн авто замын III багцын 92 км авто замын барилгын ажлыг эхлүүлэх 06/01/2022 дугаартай зөвшөөрлийг 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр олгосон. Гүйцэтгэгч компани зам барилгын ажлыг эхлүүлэхээр нүүлгэн шилжүүлэлтийн ажил эхэлсэн боловч нутгийн иргэд, малчдын эсэргүүцэлтэй тулгаран, тодорхойгүй нөхцөл байдал үүссэн. Хууль зүй дотоод хэргийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Хүрмэн сумын Жанжин багт ард иргэдтэй уулзалт хийсэн бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд Н.Нямбаатар ард иргэдээс тавьсан асуудлыг Засгийн газрын 2022 оны 5 дүгээр сарын 11-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, тус хуралдааны 28 дугаар тэмдэглэлээр авто замын бүтээн байгуулалтын бүсэд хамаарч буй орон нутгийн иргэдэд хөгжлийн төслийн бүтээн байгуулалт, ач холбогдлын талаар таниулах, нөхөн олговрын асуудлыг концесс эзэмшигч аж ахуйн нэгжтэй хамтран тохиролцож, шийдвэрлэхийг Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасан. Тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу Өмнөговь аймгийн Засаг даргын тушаалаар тус аймгийн Засаг даргын Тамгын газар, агентлаг болон концесс эзэмшигчийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр замын дагуу явж малчидтай уулзаж, төр засгийн бодлого шийдвэрийг танилцуулах оролдлого хийсэн боловч иргэд, малчид ажлын хэсгийнхнийг үг хэлүүлэхгүй, эсэргүүцсэнээр харилцан ярилцаж, тохиролцоонд хүрэх ямар ч боломж бүрдээгүй талаар Өмнөговь аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс мэдээлэл өгсөн. Ерөнхий сайд 2022 оны 05 дугаар сарын 26-наас 27-ны өдрүүдэд Өмнөговь аймагт ажилласан бөгөөд Цагаандэл-Уул боомт нээхээр шийдвэрлэсэн Засгийн газрын 2014 оны 46 дугаар тогтоолыг түдгэлзүүлэх асуудлыг Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаандаар хэлэлцүүлж, Цагаандэл Уул боомтын асуудлыг Өмнийн говийн хөгжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн санал, дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасан байна. Ерөнхий сайдын 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 107 дугаар захирамжаар Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагын дарга нараас бүрдсэн Цагаандэл-Уул боомтыг нээн ажиллуулахад тулгамдаж буй асуудлыг судалж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Мөн Эдийн засаг, хөгжлийн яаман дээр уг ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.</p> <p>Хүлээгдэж буй ажлууд: Ерөнхий сайдын 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 107 дугаар захирамжаар Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагын дарга нараас бүрдсэн Цагаандэл-Уул боомтыг нээн ажиллуулахад тулгамдаж буй асуудлыг судалж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн шийдвэрийг хүлээж байна.</p>

		<p>Тулгамдаж буй асуудлууд: Өмнөговь аймгийн Ханхонгор, Номгон сумдаас замын зурвас газрын зөвшөөрөл олгогдоогүй тул тухайн сумдын нутаг дэвсгэрт зам барилгын ажлыг эхлүүлэх боломж бүрдээгүй байна. Зөвшөөрөл гарсан Хүрмэн сумын нутагт зам барилгын ажлыг эхлүүлэхээр нүүлгэн шилжүүлэлтийн ажил эхэлсэн боловч нутгийн иргэд, малчдын эсэргүүцэлтэй тулгаран, тодорхойгүй нөхцөл байдал үүсээд байна.</p> <p>Шийдэл: Боомт нээх, зам барих асуудлаар Засгийн газраас тодорхой шийдэл гарсан тохиолдолд зам барилгын ажлыг эхлүүлэх боломж бүрдэнэ.</p>
3	Бичигт хилийн боомт чиглэлд: Баруун-Урт-Бичигт чиглэлийн 277.3 км хатуу хучилттай авто замын төсөл (2022-2024 он).	<p>Бэлтгэл ажлын хүрээнд:</p> <p>Концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр 2017 онд тусган, концесс олгох уралдаант шалгаруулалтыг 2018-2019 онд 2 удаа зарласан боловч шаардлага хангасан төслийн санал ирээгүй.</p> <p>Харин одоо дэлхийн зах зээл дээр тухайн зам дагууд байрладаг уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, эрэлт нэмэгдсэн тул дахин зарлахаар бэлтгэж байна.</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны газраас уралдаант шалгаруулалтын баримт бичиг боловсруулах ажлын хэсэг байгуулахаар тус яамнаас ажлын хэсэгт ажиллах албан тушаалтны нэрийг авсан.</p> <p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас концесс, төрийн хувийн хэвшлийн чиг үүргийг Эдийн засаг хөгжлийн яам хариуцах болсонтой холбогдуулан Төрийн худалдан авах ажиллагааны газарт буй төслүүдийн мэдээллийг хүлээлцэх хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаатай холбогдуулан ажлын хэсэг байгуулах ажил түр хойшлогдсон байна.</p> <p>Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан төслүүдийн явц байдлын талаар хуваарь гарган, Засгийн газрын хуралдаанд танилцуулах шийдвэрийн дагуу 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.</p> <p>Засгийн газрын хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу “Баруун-Урт-Бичигт чиглэлийн авто зам төсөл”-ийн зардал, үр ашгийн тооцоог 2 хувилбараар боловсруулж, товч танилцуулга, мэдээллийн хамт 2022 оны 05 дугаар сарын 11-ний 03/2161 тоот албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 179 дүгээр тогтоолоор Баруун-Урт-Бичигт чиглэлийн замын концесс олгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт даалгасан.</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн албан бичгийн дагуу 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдөр концесс олгох ажлын хэсэгт ажиллах албан тушаалтны нэрсийг хүргүүлсэн бөгөөд ажлын хэсэг байгуулагдсан.</p> <p>Тулгамдаж буй асуудлууд: Төрийн худалдан авах ажиллагааны газраас ажлын хэсэг байгуулж, концесс олгох уралдаант шалгаруулалтын баримт бичиг боловсруулах, шалгаруулалтыг зарлах ажил хүлээгдэж байна.</p> <p>Шийдэл: Эдийн засаг, хөгжлийн яамнаас тус төслүүдийн асуудлаар хариуцан ажиллаж байна. Боомт нээх, зам барих асуудлаар Засгийн газраас тодорхой шийдэл гарсан тохиолдолд зам барилгын ажлыг эхлүүлэх боломж бүрдэнэ.</p>

Тав. Дүгнэлт.

5.1.Төлөвлөлтийн байдал:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д “Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол

Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх дараах Хөгжлийн зорилтот хөтөлбөр байна гэж” заасан боловч Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн санхүүжилт, хэрэгжүүлэх хугацаа, шалгуур үзүүлэлт нь тодорхой бус байгаа тул хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэл учруулахаар байна.

5.2. Хэрэгжилтийн байдал:

Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөгжлийн төслүүдийг салбараар нь ангилахад төмөр замын 9, авто замын 17, нисэх онгоцны буудлын 8, боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх 8, нийт 42 төсөл байгаагаас 100 хувь хэрэгжсэн 6, 90 хувийн хэрэгжилттэй 1, 70 хувийн хэрэгжилттэй 2, 50 хувийн хэрэгжилттэй 3, 30 хувийн хэрэгжилттэй 10, хэрэгжилтийн хугацааг тооцох болоогүй 17, Зам, тээврийн хөгжлийн яамнаас үл хамаарах шалтгаантай 3 төсөл арга хэмжээ байгаа ба хэрэгжилтийн дундаж 58.2 хувьтай байна.

Гашуунсухайт-Ганцмод боомтуудыг төмөр замаар холбох төсөл (7.9 км) нь Монгол Улс болон БНХАУ хоорондын хэлэлцээрээс шалтгаалах тул Шинэ сэргэлтийн бодлогод заасан хугацаанд хэрэгжих боломжгүй юм.

Нисэх онгоцны буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүдийн Концессын үр ашгийн тооцооллыг Төрийн өмчийн хорооны 2010 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 153 дугаар тогтоолоор баталсан “Концессын зүйлийн зардал, үр ашгийн тооцоо хийх түр аргачлал”-ын дагуу боловсруулсан бөгөөд урьдчилсан тооцооллын үр дүнгээр уг төслийн NPV/Цэвэр өнөөгийн үнэ цэнэ Чойбалсан -71.2 тэрбум, Дэглийцагаан -69 тэрбум, Ховд - 57.8 тэрбум, Мөрөн - 29.5 тэрбум төгрөг тус тус байна. Зорчигч урсгалын тоо бага, хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр зэргээс шалтгаалж, алдагдалтай байгаа бөгөөд ЭЗХЯ-аас төслийн цэвэр өнөөгийн үнэ цэнэ 0-ээс бага байгаа тул концессын жагсаалтад оруулах боломжгүй байгаа талаар мэдээлсэн. Иймээс орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийг концессын зүйлийн жагсаалтад оруулах асуудал хүлээгдэж хэрэгжилт удаашралтай байна.

Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх ТЭЗҮ, зураг төсөл, санхүүжилтгүй хүлээгдэж байгаа төслүүд, ялангуяа Эрэнцав, Арцсуурь боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг дахин нягталж Эдийн засаг, хөгжлийн яам, Боомтын сэргэлтийн үндэсний хороотой хамтарч нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, батлуулах шаардлагатай байна.

Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлаас шалтгаалж 2022 онд авто зам барилгын ажил нь эхлээгүй 2 (Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто замын төсөл, Баруун-Урт-Бичигт чиглэлийн 277.3 км хатуу хучилттай авто замын төсөл) арга хэмжээ байна.

Зургаа. Санал, зөвлөмж

6.1. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх хугацаа, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлон төлөвлөгөөг батлуулах;

6.2. "Чингис хаан" олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг өргөтгөх төсөл, Олон улсын ачаа тээврийн транзит төв болгох төслийг нэгтгэж нэг төсөл болгох, Орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийг концессын зүйлийн жагсаалтад оруулах чиглэлээр ЭЗХЯ-тай хамтран ажиллах;

6.3. Монгол Улсын 2023 оны төсөвт шинээр эхлүүлэх төсөл арга хэмжээ тусгаагүй тул худалдан авах ажиллагаанаас шалтгаалж 2022 онд авто зам барилгын ажил нь эхлээгүй 2 төсөл арга хэмжээг 2024 он буюу түүнээс хойш эхлүүлэх;

6.4. Чойбалсан-Хөет-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр замын төсөлтэй холбоотой шүүхийн маргаантай асуудлыг шийдвэрлүүлэн, төслийн ажлын явцыг эрчимжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллахад анхаарах;

6.5. Зураг төсөл, ТЭЗҮ, санхүүжилтийн эх үүсвэргүй боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх хүлээгдэж буй төслүүдийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг дахин судалж Эдийн засаг, хөгжлийн яам, Боомтын сэргэлтийн үндэсний хороотой хамтарч нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, батлуулах.